



# ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2014 оны 11 дүгээр сар

## Гадаад худалдааны эргэлт: \$10,022.6 сая

**Мөнгөн дүн** тайлант хугацааны эцэст 10,022.6 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 3.2%-иар буюу 306.1 сая ам.доллараар өссөн. Үүнд импорт 1,023.1 сая ам.доллараар буурсан ч экспорт 1,329.3 сая ам.доллараар өссөн нь нөлөөлөв.

**Хөрш орнуудтай хийсэн худалдааг** авч үзвэл, нийт бараа эргэлтийн 61.7% буюу 6,185.6 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 14.8% буюу 1,484.7 сая ам.долларын худалдааг ОХУ-тай тус тус хийсэн байна. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 24.4%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 0.5%-иар тус тус өсчээ.

## Гадаад худалдааны нийт тэнцэл: \$358.2 сая

**Мөнгөн дүн** 2014 оны эхний 11 сарын байдлаар гадаад худалдааны тэнцлийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 2,352.4 сая ам.доллараар буурснаар 358.2 сая ам.долларын ашигтай гарлаа. Энэ нь экспорт 34.4%-иар өссөн, импорт 17.5%-иар буурсантай холбоотой байна.

**Экспорт, импортын жилийн өсөлтийн зөрүүг** 3 сарын шаталсан дунджаар (moving average) авч үзвэл сүүлийн жилүүдэд байнгын бууралттай байсан бол 2014 оны эхнээс өсөх хандлага руу орсон. Энэ нь оны эхнээс экспортын өсөлт нэмэгдэж, импортын өсөлт буурсантай холбоотой байна.

## Валютын төлбөртэй худалдааны тэнцэл: \$650.5 сая

Валютаар төлбөр тооцоог нь гүйцэтгэсэн худалдааны тэнцэл нь төгрөгийн валюттай харьцах ханшид нөлөөлдөг суурь үзүүлэлт юм. Сүүлийн 2 жилийн хугацаанд тогтмол алдагдалтай байсан валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2014 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр 650.5 сая ам.долларын ашигтай буюу өнгөрсөн оны мөн үеэс 2,227.8 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлттэй байна. Үүнд валютын төлбөртэй экспорт 33.1%-иар өссөн, импорт 17.6%-иар буурсан нь нөлөөлсөн.

## Гадаад худалдааны нөхцөл: 1.593 (Туршилт тооцоо)

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс /2012 суурьтай/ тайлант хугацааны эцэст 1.593-д хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 15.5%-иар өслөө.


Экспортын үнийн индекс 7.6%-иар өсч, импортын үнийн индекс 6.9%-иар буурсан нь гадаад худалдааны нөхцөлийн индекс ийнхүү өсөхөд нөлөөлжээ.

Экспортын үнийн индекс өсөхөд зэсийн баяжмалын экспортын үнийн өсөлт, импортын үнийн индекс буурахад удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн, нефтийн бүтээгдэхүүний хилийн үнэ буурсан нь тус тус голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	Эхний 11 сар			Өөрчлөлт			
	2014	2013	2012	2014/2013		2013/2012	
				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	10,022.6	9,716.4	10,298.9	306.1	3.2%	(582.5)	-5.7%
Экспорт	5,190.4	3,861.2	4,029.9	1,329.3	34.4%	(168.7)	-4.2%
Импорт	4,832.2	5,855.3	6,269.1	(1,023.1)	-17.5%	(413.8)	-6.6%
Тэнцэл	358.2	(1,994.1)	(2,239.2)	2,352.4	-118.0%	245.1	-10.9%


Дүрслэл 1. Экспорт, импортын өсөлтийн хурд /3 сарын гулсах дунджаар/



Дүрслэл 2. Валютын төлбөртэй худалдаа



Дүрслэл 3. Худалдааны нөхцлийн индексийн өөрчлөлт /3 сарын гулсах дунджаар/



## Бүтэц: 89% + 11%

Ашигт малтмалын бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар өсч нийт экспортын 89%-ийг бүрдүүлэв.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр ба баяжмал, боловсруулаагүй нефть гэсэн голлох 4 түүхий эдийн экспорт ашигт малтмалын экспортын 88%, нийт экспортын 78%-ийг тус тус эзэлж байна.

Түүнчлэн энэ 4 бүтээгдэхүүний ашигт малтмалын экспортод эзлэх хувь 3.3 нэгж хувиар, нийт экспортод эзлэх хувь 3.2 нэгж хувиар тус тус өссөн байна.

## Өсөлт: +34.4%

Экспорт өнгөрсөн оны мөн үеэс 34.4%-иар өссөн бөгөөд уг өсөлтийн 30.8%-ийг ашигт малтмалын экспортын өсөлт бүрдүүлсэн байна. Гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл зэсийн баяжмал болон боловсруулаагүй нефтийн экспортын өсөлт нь уг бүлгийн өсөлтийн 47%-ийг бүрдүүлжээ. Харин чулуун нүүрс болон төмрийн хүдрийн экспорт өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 24%, 32%-иар буурсан нь уг бүлгийн өсөлтийг 13%-иар бууруулжээ.

## Өөрчлөлт

Экспортын бүтээгдэхүүн тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалж 1,236.6 сая ам.доллараар, үнийн өсөлтөөс шалтгаалж 92.7 сая ам.доллараар тус тус өссөнөөр нийтдээ 1,329.3 сая ам.доллараар өссөн байна.

Бүлэг тус бүрээр авч үзвэл ашигт малтмалын экспортын хувьд зэсийн баяжмал болон боловсруулаагүй нефтийн тоо хэмжээ өссөнөөс шалтгаалж 1,146 сая ам.доллараар өсөх нөлөө үзүүлсэн бол төмрийн хүдэр, цайрын экспортын тоо хэмжээ буурснаас, мөн чулуун нүүрс, төмрийн хүдрийн үнэ буурснаас шалтгаалж экспорт 517 сая ам.доллараар буурсан байна.

Ноос, ноолууран бүтээгдэхүүний үнэ, бусад экспортын бүтээгдэхүүний үнэ болон тоо хэмжээ өссөнөөр өмнөх оны мөн үеэс харгалзан 40.9 болон 100.9 сая ам.доллараар экспорт өссөн байна.

## Дэлхий зах зээл дээрх түүхий эдийн үнэ

Алтны дэлхийн зах зээл дээрх үнэ 2014 оны 11 дүгээр сарын 28-ны байдлаар унц тутамд 1,167.4-д хүрснээр өнгөрсөн оны мөн үеэс 6.9%-иар, өмнөх сараас 0.5%-иар тус тус буурсан байна.


А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн үнэ 2014 оны 11 дүгээр сарын 28-ны байдлаар 6,412.0, 70.0 ам.долларт хүрч өнгөрсөн сарын мөн үеэс зэс 5.2%-иар, төмрийн хүдэр 11.4%-иар, өмнөх жилийн мөн үеэс зэс 9.1%-иар, төмрийн хүдэр 48.7%-иар тус тус буурсан байна.

## Хүснэгт 2. Экспортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

	2014			2013			Өөрчлөлт		
	Тоо/хэм (мян.тн.к)	Дүн	%	Тоо/хэм (мян.тн.к)	Дүн	%	Дүн	%	% 2
<b>1. Ашигт малтмал</b>	<b>4,596</b>	<b>89%</b>		<b>3,409</b>	<b>88%</b>		<b>1,187</b>	<b>↑35%</b>	<b>30.8%</b>
Чулуун нүүрс	16,909	760	15%	15,971	1,002	26%	(242)	↓-24%	-7%
Зэсийн баяжмал	1,253	2,288	44%	586	851	22%	1,437	↑169%	42%
Төмрийн хүдэр/баяж.	5,554	401	8%	5,987	591	15%	(191)	↓-32%	-6%
Боловсруулаагүй нефть	6,330	602	12%	4,532	447	12%	155	↑35%	5%
Цайрын хүдэр ба баяж.	93	106	2%	121	110	3%	(4)	↓-4%	0%
Мөнгөжөөгүй алт	8,423	343	7%	7,384	304	8%	39	↑13%	1%
Жонш, лейцит, нефелинт	287	66	1%	310	77	2%	(12)	↓-15%	0%
Молибдений хүдэр/баяж	4	32	1%	4	27	1%	5	↑20%	0%
<b>2. Ноос, ноолуур</b>	<b>276.4</b>	<b>5%</b>		<b>235.5</b>	<b>6%</b>		<b>41</b>	<b>↑17%</b>	<b>1%</b>
Ямааны угаа, ноолуур	4,015	223	4%	3,988	185	5%	37.6	↑20%	16%
Ямааны сам, ноолуур	554	54	1%	511	50	1%	3.3	↑7%	1%
<b>3. Бусад</b>	<b>318</b>	<b>6%</b>		<b>217</b>	<b>6%</b>		<b>101</b>	<b>↑47%</b>	<b>3%</b>
<b>Нийт дүн</b>	<b>5,190</b>			<b>3,861</b>			<b>1,329.3</b>	<b>↑34.4%</b>	

% 2 - Өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)

## Дүрслэл 4. Чулуун нүүрсний экспорт, зах зээлийн үнэ (ам.доллар)



## Хүснэгт 3. Экспортын барааны өөрчлөлт (сая ам.доллар)

	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
		%		%		%
<b>1. Ашигт малтмал</b>	<b>1174</b>		<b>13</b>		<b>1,187</b>	
Чулуун нүүрс	59	24%	(301)	-124%	(242)	-24%
Зэсийн баяжмал	969	67%	468	33%	1,437	169%
Төмрийн хүдэр ба баяжмал	(43)	-22%	(148)	-78%	(191)	-32%
Боловсруулаагүй нефть	177	16%	(23)	-15%	155	35%
Цайрын хүдэр ба баяжмал	(25)	-613%	21	513%	(4)	-4%
Мөнгөжөөгүй алт	43	110%	(4)	-10%	39	13%
Жонш, лейцит, нефелинт	(6)	-50%	(6)	-50%	(12)	-15%
Молибдений хүдэр ба баяжмал	0	2%	5	98%	5	20%
<b>2. Ноос, ноолуур</b>	<b>5.5</b>		<b>35.4</b>		<b>40.9</b>	
Ямааны угаасан ноолуур	1.3	3%	36.4	97%	37.6	20%
Ямааны самнасан ноолуур	4.2	129%	(0.9)	-29%	3.3	7%
<b>3. Бусад</b>	<b>57</b>	<b>56%</b>	<b>44</b>	<b>44%</b>	<b>100.9</b>	<b>47%</b>
<b>Нийт</b>	<b>1,236.6</b>		<b>92.7</b>		<b>1,329.3</b>	

## Дүрслэл 5. Дэлхийн зах зээл дээрх алт, цайр, зэсийн үнийн динамик



## Бүтэц: 26% + 41% +22%

Эхний 11 сарын байдлаар нийт импортын 26%-ийг хэрэглээний бүтээгдэхүүн, 41%-ийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 22%-ийг нефтийн бүтээгдэхүүн тус тус бүрдүүлж байна.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 4%-иар буурсан бол нефтийн бүтээгдэхүүний хувийн жин өнгөрсөн оны мөн үеийн түвшинд хадгалагдсан байна.

## Өсөлт: -17.5%

Импортын бууралтыг ерөнхий ангиллаар задалвал хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт нь 12%-ийг, нефтийн бүтээгдэхүүний импортын бууралт 4%-ийг тус тус тайлбарлаж байна. Эхний 3 сарын байдлаар нефтийн импорт нийт импортын бууралтын 8%-ийг тайлбарлаж байсан бол 2 дугаар улирлаас эхлэн нефтийн импорт өссөнөөр уг үзүүлэлт 4% болж буурсан байна.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт өмнөх оноос 25%-иар буюу 674 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 16%-иар буюу 207 сая ам.доллараар буурсан нь нийт импортыг 17.5%-иар буюу 1,023 сая ам.доллараар буурахад голлон нөлөөлжээ.

## Задаргаа

**Хэрэглээний бүтээгдэхүүний импорт** өнгөрсөн оны мөн үеэс 11%-иар буюу 147 сая ам.доллараар буурахад удаан эдэлгээтэй барааны импорт, ялангуяа суудлын автомашин, түүний сэлбэг хэрэгслийн импорт 26%-иар буурсан нь голлон нөлөөлжээ. Хэрэглээний барааны импортын 3 сарын гулсах дунджаар тооцсон жилийн өсөлт тайлант хугацааны эцэст сөрөг тэмдэгтэй 15%-д хүрсэн /Дүрслэл 7/. Түргэн эдэлгээтэй хэрэглээний барааны импортын өсөлт 2013 оны эхнээс эхлэн тогтмол түвшинд байсан бол 7 сараас эхлэн буурах хандлагатай болсон. Харин удаан эдэлгээтэй хэрэглээний барааны импортын өсөлт 2013 оны 8 сараас эхлэн тогтмол буурсан байна.

**Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт** буурахад машин, механизм, тоног төхөөрөмж, түүний эд анги 38%-иар буюу 650 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлсөн. Харин барилгын материалын импорт өнгөрсөн оны мөн үеэс 2%-иар буюу 13 сая ам.доллараар өсчээ.

**Аж үйлдвэрлэлийн орцын импорт** 1%-иар буюу 4 сая ам.доллараар буурч, өнгөрсөн оны түвшинд хадгалагдсан байна. Оюутолгойн зэс, алтны уурхайн үйл ажиллагаа жигдэрснээр 2013 оны 5 сараас эхлэн эрчим хүчний импорт нэмэгдсэн.

**Нефтийн бүтээгдэхүүний импорт** 16%-иар буюу 207 сая ам.доллараар буурчээ. Дүрслэл 8-с үзэхэд хилийн үнэ 2012 оны сүүлээс эхлэн буурч, 2013 оны 9 сараас өсөх хандлагатай байсан хэдий ч 2013 оны төгсгөлөөс эхлэн буцаад буурч байна.

Хүснэгт 4. Импортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)


Төрөл	2014		2013		Өөрчлөлт		
	Дүн	%	Дүн	%	Дүн	Хувь	Хувь2*
<b>Хэрэглээний бүтээгдэхүүн</b>	<b>1,252</b>	<b>26%</b>	<b>1,399</b>	<b>24%</b>	<b>(147)</b>	<b>-11%</b>	<b>-3%</b>
Түргэн эдэлгээтэй	685	14%	709	12%	(24)	-3%	-2%
Хүнс	479	10%	508	9%	(28)	-6%	-2%
Эм, тариа	70	1%	69	1%	1	2%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	136	3%	132	2%	4	3%	0%
Удаан эдэлгээтэй	567	12%	690	12%	(124)	-18%	-9%
Гутал, хувцас, цүнх	53	1%	51	1%	3	5%	0%
Гэр ахуйн цах. хэрэгсэл ба тавилга	122	3%	139	2%	(17)	-12%	-1%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	323	7%	435	7%	(112)	-26%	-8%
Бусад удаан эдэлгээтэй бараа	68	1%	66	1%	2	3%	0%
<b>Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн</b>	<b>1,983</b>	<b>41%</b>	<b>2,657</b>	<b>45%</b>	<b>(674)</b>	<b>-25%</b>	<b>-12%</b>
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	1,044	22%	1,694	29%	(650)	-38%	-24%
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	259	5%	543	9%	(283)	-52%	-11%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	785	16%	1,151	20%	(366)	-32%	-14%
Барилгын материал	732	15%	719	12%	13	2%	1%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	207	4%	245	4%	(38)	-15%	-1%
<b>Аж үйлдвэрлэлийн орц</b>	<b>633</b>	<b>11%</b>	<b>637</b>	<b>9%</b>	<b>(4)</b>	<b>-1%</b>	<b>0%</b>
Хүнсний орц	31	1%	18	0%	13	70%	2%
Химийн бүтээгдэхүүн	84	2%	89	2%	(4)	-5%	-1%
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	15	0%	23	0%	(8)	-36%	-2%
Цахилгаан эрчим хүч	106	2%	92	2%	14	15%	3%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	0	0%	1	0%	(0)	-16%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалт	297	6%	315	5%	(18)	-6%	-3%
<b>Нефтийн бүтээгдэхүүн</b>	<b>1,052</b>	<b>22%</b>	<b>1,259</b>	<b>22%</b>	<b>(207)</b>	<b>-16%</b>	<b>-4%</b>
Дизель түнш	592	12%	785	13%	(193)	-25%	-15%
АИ-92, АИ-95	294	6%	286	5%	8	3%	1%
А-80 болон бусад	166	3%	189	3%	(23)	-12%	-2%
<b>Бусад</b>	<b>13</b>	<b>0%</b>	<b>3</b>	<b>0%</b>	<b>10</b>	<b>309%</b>	<b>0%</b>
<b>Нийт дүн</b>	<b>4,832</b>		<b>5,855</b>		<b>(1,023)</b>	<b>-17.5%</b>	

\*%2 - Ерөнхий бүлгийн өсөлтөд оруулсан хувь нэмж (contribution to the growth)

Дүрслэл 6. Нийт импортын задаргаа /3 сарын гулсах дундаж/



Дүрслэл 7. Хэрэглээний импортын хандлага /3 сарын гулсах дундаж/



Дүрслэл 8. Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ

